



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2001 оны 10 дугаар
сарын 11-ны өдөр

Дугаар 322

Улаанбаатар
хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2001 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Батхүү овогтой Баттулгыг Франц улсын Эколе Супериор Электрисите сургуулийн докторантурт автоматжуулалтын чиглэлээр, Сангидулам овогтой Наранбатыг Англи улсын Роберт Гордоны Их сургуулийн магистрантурт мэдээллийн системийн чиглэлээр тус тус 1 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт Их сургуулийн докторантурт улс төр судлалын чиглэлээр суралцаж буй Мишиг овогтой Энхбаярын үлдсэн 13 сарын тэтгэлгийг үргэлжлүүлэн олгосугай.

3. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Гэгээрлийн сайдын 2000 оны 192 дугаар тушаалын хавсралтын 10, мөн сайдын 2000 оны 168 дугаар тушаалын хавсралтын 26-г тус тус хүчингүй болгосугай.

САЙД

А.Цанжид

А.ЦАНЖИД

Хуудвар

үрэт: с/м Б. Энхтөгс

2001.10.15